

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООДЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-4

1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	3-4
--	------------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодын
05 дугаар сарын 07-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 45 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 51.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 22 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батцэцэг, Ж.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Б.Мөнхсоёл, Б.Чойжилсүрэн;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, О.Амгаланбаатар, П.Батчимэг, Ж.Ганбаатар, Г.Дамдинням, М.Мандхай, П.Мөнхтулга, З.Мэндсайхан, Н.Наранбаатар, У.Отгонбаяр, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, А.Ундраа, Ж.Чинбүрэн.

Нэг.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн хуулийн төслийн эцсийн хувилбарыг Байнгын хорооны гишүүдэд тараасан тухай мэдэгдэв.

Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хороодоос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 04 минут үргэлжилж, 45 гишүүнээс 26 гишүүн хүрэлцэн ирж, 57.8 хувийн ирцтэйгээр 13 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр,

Лхагва гараг

Төрийн ордон “Үндсэн хууль”

танхим

13 цаг 22 минут.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Даваасүрэн: Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооныхон орж ирж ирцээ бүрдүүлье.

Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье. Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүдийн хамтарсан хуралдааныг эхлүүлье.

Хуралдаанд ирвэл зохих 45 гишүүнээс 23 ирж, 51.1 хувийн ирцтэй байгаа тул Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн хамтарсан хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг. Нэг л асуудал байгаа.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг би та бүхэнд танилцуулъя. Ж.Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Ц.Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Д.Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Д.Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга гэсэн хүмүүс өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцогдох тухай хуулийн төслийн эцсийн хувилбарыг та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгье.

Алга байна.

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн тэгж бичээгүй юм байна шүү. Улсын Их Хурлын гишүүн саналаараа танилцуулах гишүүн байна уу гишүүд ээ? Чуулганы нэгдсэн хуралдаанд та танилцуулах уу? Бейсен дарга өөрөө танилцуулна Байнгын хорооны дарга.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэнгийн гаргасан хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан тогтоолын төсөл боловсруулан батлуулах санал дэмжигдсэн тул Байнгын хорооны тогтоол боловсруулах, Байнгын хорооны тогтоолыг гэгчихсэн юм байх юм. Тэгвэл Их Хурлын тогтоол юм уу айн? Дэмжигдсэн тул “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг оруулж ирэх юм уу, юу гэж биччихсэн юм та хэд?

Ингээд Бадамсүрэн гишүүний санал дэмжигдсэнтэй холбогдуулаад ирэх долоо хоногт Байнгын хорооны тогтоолын төсөл хууль санаачлагч, тэгээд 2 Байнгын хорооны гишүүдтэй хамтраад тогтоолын төсөл боловсруулж оруулж ирье.

Ингээд өнөөдрийн 2 Байнгын хорооны хамтарсан хуралдаан хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууслаа. Баярлалаа гишүүд ээ.

13.26 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР